БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/124/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Булган хот

2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт ........ 2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл........ 4
3. Аудитын тайлан ........ 9
   3.1 Ерөнхий зүйл ........ 9
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт........ 9
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 10
   3.4 Материаллаг байдал ........ 10
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 10
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 11
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........ 12
   3.8 Аудитын гол асуудал ........ 12
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 12
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........ 13
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........ 13
4. Аудитын илрүүлэлт........ 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 14


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХАА | Хөдөө аж ахуй |

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.24 № 39

танай_______________ны №_______________т

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Б.БАТБОЛД ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020017

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **124,184,912.94** | **147,972,854.11** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **124,184,912.94** | **147,972,854.11** |
| **351** | **Түүхий эд материал** | **31,269,334.28** | **43,058,349.83** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 24,344,110.00 | 31,943,209.50 |
| 35130 | Эм боох материал | 6,925,224.28 | 11,115,140.33 |
| **354** | **Хангамжийн материал** | **92,915,578.66** | **104,914,504.28** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,546,179.04 | 3,298,254.04 |
| 35420 | Аж ахуйн материал | 70,213,534.36 | 74,969,487.98 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 16,662,600.00 | 22,230,324.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,493,265.26 | 4,416,438.26 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **207,139,081.32** | **208,406,110.65** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **207,139,081.32** | **208,406,110.65** |
| **392** | **Биет хөрөнгө** | **156,212,081.32** | **157,479,110.65** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 65,249,310.00 | 65,249,310.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -5,270,709.47 | -7,719,131.92 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 179,979,860.00 | 198,979,860.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -127,973,376.44 | -127,673,565.64 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 336,724,395.16 | 346,553,795.16 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -296,063,785.18 | -319,926,671.24 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 38,360,545.18 | 39,442,545.18 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -34,794,157.93 | -37,427,030.89 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **50,927,000.00** | **50,927,000.00** |
| 39301 | Программ хангамж | 1,013,000.00 | 1,013,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,013,000.00 | -1,013,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 50,927,000.00 | 50,927,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **331,323,994.26** | **356,378,964.76** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **331,323,994.26** | **356,378,964.76** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **331,323,994.26** | **356,378,964.76** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | 437,965,840.30 | 437,965,840.30 |
| 51101 | Өмч: - төрийн | 437,965,840.30 | 437,965,840.30 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **-197,106,880.32** | **-172,051,909.82** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -228,122,616.31 | -197,106,880.32 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 31,015,735.99 | 25,054,970.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 90,465,034.28 | 90,465,034.28 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **331,323,994.26** | **356,378,964.76** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **762,162,813.00** | **739,240,820.20** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **20,430,600.00** | **47,714,820.20** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **20,430,600.00** | **47,714,820.20** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 20,430,600.00 | 47,714,820.20 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,982,100.00 | 4,514,900.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 13,448,500.00 | 43,199,920.20 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **741,732,213.00** | **691,526,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **731,634,300.00** | **690,648,000.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 731,634,300.00 | 690,648,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **9,800,000.00** | **878,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,800,000.00 | 878,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **297,913.00** | **0.00** |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 297,913.00 | 0.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **731,147,077.01** | **714,185,849.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **731,147,077.01** | **714,185,849.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **622,641,532.24** | **645,259,611.36** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **410,788,198.59** | **416,960,653.00** |
| 210101 | Үндсэн цалин | 306,867,277.51 | 318,400,690.00 |
| 210102 | Нэмэгдэл | 82,264,266.96 | 73,005,322.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,231,626.12 | 18,015,459.00 |
| 210104 | Урамшуулал | 6,425,028.00 | 7,539,182.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **52,422,233.64** | **54,829,330.66** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,021,828.70 | 39,647,065.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,083,155.51 | 4,000,526.98 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгал | 3,253,085.21 | 3,123,181.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 811,792.45 | 732,559.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,252,371.77 | 7,325,997.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **43,607,789.00** | **47,361,987.00** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 3,298,025.00 | 3,831,087.00 |
| 210302 | Түлш, халаалт | 38,518,150.00 | 41,370,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,791,614.00 | 2,160,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **29,394,616.64** | **27,671,515.08** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,927,283.00 | 5,083,885.70 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,112,355.00 | 13,072,026.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 7,417,660.00 | 6,656,980.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 200,000.00 | 250,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,737,318.64 | 2,608,623.38 |
| **2105** | **Норматив зардал** | **6,673,850.14** | **6,835,573.95** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,527,900.14 | 5,385,273.95 |
| 210502 | Хоол, Хүнс | 2,145,950.00 | 1,450,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,155,190.00** | **13,453,040.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 4,009,630.00 | 7,013,310.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,145,560.00 | 6,439,730.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **15,544,300.00** | **14,313,100.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 15,544,300.00 | 14,313,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,914,389.00** | **16,090,041.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 14,509,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 564,000.00 | 570,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 485,140.00 | 499,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 300,000.00 | 297,143.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 50,000.00 | 50,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 306,500.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 67,559.00 | 79,798.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 141,190.00 | 83,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **53,140,965.23** | **47,744,370.67** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 248,000.00 | 100,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал | 52,892,965.23 | 47,644,370.67 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **108,505,544.77** | **68,926,238.34** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **61,578,663.00** | **2,630,000.00** |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 297,913.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 50,847,300.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,433,450.00 | 2,630,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **46,926,881.77** | **66,296,238.34** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 46,926,881.77 | 66,296,238.34 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **31,015,735.99** | **25,054,970.50** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | 31,015,735.99 | 25,054,970.50 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 748,714,313.00 | 696,040,900.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 6,982,100.00 | 4,514,900.00 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,982,100.00 | 4,514,900.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,982,100.00 | 4,514,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,982,100.00 | 4,514,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 741,732,213.00 | 691,526,000.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 731,634,300.00 | 690,648,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 731,634,300.00 | 690,648,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,800,000.00 | 878,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,800,000.00 | 878,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 297,913.00 | 0.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 297,913.00 | 0.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | 726,921,413.00 | 685,129,500.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 726,921,413.00 | 685,129,500.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 618,415,868.23 | 616,203,261.66 |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 410,788,198.59 | 416,960,653.00 |
| 210101 | Үндсэн цалин | 306,367,277.51 | 310,293,169.00 |
| 210102 | Нэмэгдэл | 82,764,266.96 | 73,005,322.00 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 15,231,626.12 | 18,015,459.00 |
| 210104 | Урамшуулал | 6,425,028.00 | 15,646,703.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 52,422,233.64 | 54,829,330.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,021,828.70 | 39,647,065.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,083,155.51 | 4,000,526.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,253,085.21 | 3,123,181.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 811,792.45 | 732,559.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,252,371.77 | 7,325,997.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 43,607,789.00 | 47,361,987.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,298,025.00 | 3,831,087.00 |
| 210302 | Түлш, халаалт | 38,518,150.00 | 41,370,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,791,614.00 | 2,160,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 35,260,278.00 | 33,137,010.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,117,818.00 | 7,255,410.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,426,800.00 | 18,284,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,445,660.00 | 6,687,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 200,000.00 | 250,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 70,000.00 | 659,400.00 |
| **2105** | **Норматив зардал** | 10,285,550.00 | 12,779,130.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 8,619,100.00 | 11,328,830.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,666,450.00 | 1,450,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 46,019,510.00 | 19,120,280.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 874,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 29,853,350.00 | 9,992,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,166,160.00 | 8,253,880.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 15,544,300.00 | 14,313,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 15,544,300.00 | 14,313,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,144,809.00 | 16,724,041.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,199,750.00 | 14,509,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 564,000.00 | 570,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 485,140.00 | 499,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 300,000.00 | 297,143.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 50,000.00 | 50,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 656,200.00 | 500,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 67,559.00 | 79,798.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 822,160.00 | 217,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 343,200.00 | 977,730.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 343,200.00 | 977,730.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 108,505,544.77 | 68,926,238.34 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 61,578,663.00 | 2,630,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж | 297,913.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 50,847,300.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,433,450.00 | 2,630,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 46,926,881.77 | 66,296,238.34 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 46,926,881.77 | 66,296,238.34 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 21,792,900.00 | 10,911,400.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | 21,792,900.00 | 10,911,400.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 21,792,900.00 | 10,911,400.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 21,792,900.00 | 10,911,400.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 21,792,900.00 | 10,911,400.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | -21,792,900.00 | -10,911,400.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **690,648,000.00** | **628,866,661.66** |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **690,648,000.00** | **628,866,661.66** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **687,898,000.00** | **626,236,661.66** |
| 2101 | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **444,669,700.00** | **416,582,653.00** |
| 210101 | Үндсэн цалин | 321,561,900.00 | 310,293,169.00 |
| 210102 | Нэмэгдэл | 99,004,700.00 | 73,005,322.00 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 15,668,900.00 | 17,637,459.00 |
| 210104 | Урамшуулал | 8,434,200.00 | 15,646,703.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **60,030,400.00** | **54,829,330.66** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,243,600.00 | 39,647,065.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,446,700.00 | 4,000,526.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,557,400.00 | 3,123,181.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 889,300.00 | 732,559.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,893,400.00 | 7,325,997.20 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **48,449,700.00** | **47,361,987.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,918,800.00 | 3,831,087.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,370,900.00 | 41,370,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,160,000.00 | 2,160,000.00 |
| 210304 | Байрны түрээс | - | - |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **35,594,200.00** | **33,689,010.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,515,500.00 | 7,255,410.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,590,300.00 | 17,784,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,524,900.00 | 6,687,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 250,000.00 | 250,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,713,500.00 | 1,711,400.00 |
| 2105 | **Нормативт зардал** | **14,506,600.00** | **12,779,130.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,256,600.00 | 11,328,830.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2,250,000.00 | 1,450,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | - |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **28,792,600.00** | **28,979,680.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 11,000,000.00 | 10,733,400.00 |
| 210602 | Тавилга | - | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 10,000,000.00 | 9,992,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,792,600.00 | 8,253,880.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **34,083,400.00** | **14,313,100.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | - | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 34,083,400.00 | 14,313,100.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **20,770,000.00** | **16,724,041.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,498,000.00 | 14,509,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 900,000.00 | 570,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 500,000.00 | 499,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 300,000.00 | 297,143.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 50,000.00 | 50,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,422,000.00 | 500,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 100,000.00 | 79,798.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,000,000.00 | 217,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,001,400.00** | **977,730.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 1,001,400.00 | 977,730.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,750,000.00** | **2,630,000.00** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,750,000.00** | **2,630,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,750,000.00 | 2,630,000.00 |
| 1310 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **690,648,000.00** | **690,648,000.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 690,648,000.00 | 690,648,000.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,756,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **878,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **878,000.00** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **378,000.00** |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 378,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **500,000.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **878,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **878,000.00** |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **-878,000.00** |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Булган аймаг дахь Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь "Бейкер Тилли Далайван аудит" ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймаг дахь Мэргэжлийн хяналтын газарт 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган аймаг дахь Мэргэжлийн хяналтын газар 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний "Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл, боломжийг бүрдүүлэх" үүднээс төлөвлөгөөт хяналт шалгалтыг 19 зорилтын хүрээнд нийт 83 арга хэмжээг

хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс биелэлт дунджаар 92,7 хувь байна . Ажлын төлөвлөлтийг жил, улирал, сар, 7 хоногоор гарган гүйцэтгэлийг тооцож, өдрийн бүтээмжийн үнэлгээ хийж, 48 үзүүлэлтээр улсын байцаагч, албан хаагчдын ажлыг дэлгэмэл хүснэгтээр ил тод дүгнэж ирсэн нь нийт ажиллагсдын хариуцлага, ажилдаа хандах хандлагад ахиц өөрчлөлт авчирч байгаа гэж үзэж байна. Улсын байцаагч нарын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зайлшгүй шаардлагыг үндэслэж, эрсдэлийг үнэлэх, удирдах арга аргачлалыг тодорхойлсон ажилбарууд боловсруулан хяналтын чиглэлүүдээрээ тасралтгүй ажиллаж эхэлснээр зөрчил, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, эрсдэлийг бууруулахад цаашид ач холбогдлоо илүү өгөх ажил болж байна.

Сэтгэлээс зүтгэл гарч, зүтгэлээс санаачлаг төрж, санаачилгагүйгээс ажил сайжирдаггүй байдлыг тооцож, ажилдаа шинэлэг санаачлаг гаргахыг алба хаагч бүрийн үүрэг болгож, ажил дүгнэх үзүүлэлтэд оруулсан нь ажилд сайнаар нөлөөлж байна. Аж ахуйн нэгж байгууллага иргэний зүгээс Мэргэжлийн хяналтын байгууллага руу хандсан урсгал чиглэлийг дэмжиж төлөвшүүлэх, объектоо тасралтгүй судлах, хяналт шалгалтын түүхээс илүүтэйгээр харилцааны түүх үүсгэж, программ боловсруулж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллаж байгаа нь цаашид гарах үр дүн ач холбогдол ихтэй юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймаг дахь Мэргэжлийн хяналтын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 690,648.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,906,4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 483.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймаг дахь Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,267.03 мянган төгрөгөөр буюу 0.61 хувиар, бараа материалын дүн амна оноос 23,787.94 мянган төгрөгөөр буюу 19.15 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 124,184.91 | 147,972.85 | 23,787.94 |
| Үндсэн хөрөнгө | 207,139.08 | 208,406.11 | 1,267.03 |
| **Нийт хөрөнгө** | **331,323.99** | **356,378.96** | **25,054.97** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 331,323.99 | 356,378.96 | 25,054.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **331,323.99** | **356,378.96** | **25,054.9** |

Бараа материалын хувьд оны эхэнд 124,184.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 63 242,9 мянган төгрөгийн орлого нэмэгдэж,үүнээс 3,609.1 мянган төгрөг МХЕГазраас халдвар хамгааллын хувцас, маск ариутгалын бодис зэрэг, мөн хялбаршуулсан шийтгэлийн хуудас, үнэмлэх зэрэг 88.2 мянган төгрөг нийт 4,844.8 мянган төгрөг хандиваар болон үнэгүй орлогоор бүртгэгдэж 39,810.1 мянган төгрөгийн материалыг зарлагадаж, үүнээс 2608,6 мянган төгрөгийн бараа материал акталж 147,617.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй болсон. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг-ийн дагуу эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг хэрэглэсэн.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 672,254.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бол тайлант онд тээврийн хэрэгсэл болох 38.0 сая төгрөгөөр, тоног төхөөрөмж 9,829.4 мянган төгрөг, тавилга эд хогшил 1,082.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж 47,644.4 мянган төгрөгийн элэгдэл тооцож 208,406.1 мянган төгрөгийн үлдэгдэл хөрөнгө байна.

Программ хангамжийн үлдэгдэл оны эхэнд 1,013.0 мянган төгрөг байсан бол хуримтлагдсан элэгдэл 1,013.0 мянган төгрөг болж элэгдлээрээ өртгөө нөхсөн биет бус хөрөнгө байна. Мөн байгууллагын конторын зориулалттай 0177112 дугаар бүхий 4,092.7 га газрыг эзэмших эрхийн гэрчилгээтэйгээр 40,927.0 мянган төгрөгөөр, зуслангийн зориулалт бүхий 5000 м2 газрыг 10,000.0 мянган төгрөгөөр, нийт 50,927.0 мянган төгрөгийн газар бүртгэлтэй биет бус хөрөнгө байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган аймаг дахь Мэргэжлийн хяналтын газар 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,022,164.70 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,022,164.70 мянган төгрөгөөр тооцож, үүнээс 1,196,294.80 мянган төгрөг барилга байгууламж төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 135,221.90 мянган төгрөгөөр бууруулан 690,648.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 690,648.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 4,514.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, нэмэлт санхүүжилтээр 878.0 мянган төгрөг урсгал үйл ажиллагаанд 628,866.66 мянган төгрөгийг зарцуулж, 66,296.24 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 628,866.66 мянган төгрөг буюу 9 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 28,087.05 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 5,201.07 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,087.71 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 1,905.2 мянган төгрөг, норматив зардлыг 1,727.47 мянган төгрөг, томилолтыг зардлыг 19,770.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн зардлыг 4,045.96 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 23,67 мянган төгрөг, Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал зардлыг 120.0 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн орлогоор 878,0 мянган төгрөгийг МХЕГазраас ковид 19 өвчний дархлаажуулалтанд зориулж олгосон нь: 500.0 мянган төгрөг шатахуунд, 378.0 мянган төгрөг нь 3 байцаагчийн ковид-19 вакцинд хяналт тавьсан хоолны зардалд олгосон.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган аймаг дахь мэргэжлийн хяналтын газар нь Шилэн дансанд бүх мэдээллийг байршуулж хугацаа хоцроосон зүйлгүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Мэргэжлийн хяналтын газар нь өмнөх онд зөвлөмжгүй зөрчилгүй дүгнэлт авсан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, урсгал засварын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,080.55 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 993,05 мянган төгрөгийн алдааг залруулж, 87.5 мянган төгрөгийн 1 акт, материаллаг бус алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

638.0 мянган төгрөгийн дотоодын томилолт гүйцэтгэх ажлын удирдамж, гүйцэтгэсэн ажлын тайлан байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасны дагуу анхан шатны баримтын дагалдах баримтыг бүрэн хавсарган гүйлгээг хийж хэвших зөрчсөн тул залруулсан. Шатахууны гэрээний дагуу төлбөрийн дүнгээс 3%-ын урамшуулал тооцоход 548.5 мянган төгрөг байх ба 355.0 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5-д "Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэнэ" заалтын дагуу үнэ төлбөргүй орлогод бүртгэх заалтыг зөрчсөн тул залруулсан.

### 4.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх хэмжээний алдаа зөрчил гаргаагүй болно.

### 4.3 Акт

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу е баримтгүй 87.5 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасны дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших гэсэн заасныг зөрчсөн байна.

*Өгсөн акт:*

Цахим баримтаар гүйлгээг хийж хэвших, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Групптэй ажилчдын амралтын бодохдоо групптэй хүнд нэмж олгох 5 хоногийг нэмж амруулаагүй 5 хоногийн амралтын мөнгийг ажилласан цалингаар бодож олгосон

байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" гэсэн заалтаар амралтын хоногийг нэмж биеэр амрааж амралтын мөнгийг тооцож олгох заалттай нийцэхгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Холбогдох хууль тогтоомжийг баримтлан гаргасан тушаал, журмыг баримтлан үндэслэл болгон амралтын хоногийг өгөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Мэргэжлийн хяналт газар | 4 | 1,080.55 | 2 | 993.05 | 1 | 87.5 | | | 1 | - |
| Дүн | | 4 | 1,080.55 | 2 | 993.05 | 1 | 87.5 | | | 1 | - |

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

<u>БЭЛТГЭСЭН:</u>

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР: Б.ПҮРЭВСҮРЭН

<u>ХЯНАСАН:</u>

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР,ЗАХИРАЛ : Д.МЯГМАРСҮРЭН

<u>АНХАН ШАТАНД ХЯНАСАН:</u>

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР: Ж.ЭНХЦООДОЛ

<u>ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:</u>

БУЛГАНАЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Д.АНХБАЯР